




## КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

Баримт бичгийн мэдээлэл	
Баримт бичгийн дугаар:	ЖР015
Баримт бичгийн хувилбарын дугаар:	1.0
Хүчин төгөлдөр болсон огноо:	2022.04.04
Мэдээллийн ангилал:	Нээлттэй
Хариуцагч	Дэд захирал

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Баталсан:	Самдан овогтой Батжаргал	Гүйцэтгэх захирал	
Боловсруулсан:	Баянцогт овогтой Доржсэмбэ	Дэд захирал	

**ӨӨРЧЛӨЛТИЙН ТҮҮХ**

Хувилбар дугаар	Огноо (Он/Сар/Өдөр)	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянагдсан	Баталсан
1.0	2022.04.04	Баянцогт овогтой Доржсэмбэ	Анхны хувилбар	<i>[Signature]</i>	

**ТҮГЭЭЛТИЙН ЖАГСААЛТ**

Хуулбарын дугаар	Түгээсэн /илгээсэн/ газар	Огноо	Гарын үсэг	Буцаасан	
				Огноо	Гарын үсэг
1.0	Нягтлан бодогчийн 000078 дугаарт шүүгээ	2022.04.04			

**ИШЛЭЛ БАРИМТ БИЧГҮҮД**

Д/д	Нэр	Дугаар/Огноо
1	Компанийн тухай хууль	2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр
2	Компаний засаглалын кодекс	2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр
3	Нууцын тухай журам	ЖР002

## АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	1
ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ.....	1
ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, НИЙТЭД ИЛ БОЛГОХ МЭДЭЭЛЛҮҮД.....	1
ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ, ЗӨВШӨӨРӨЛ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ.....	2
ТАВ. ТАЙЛАГНАЛ.....	3
ЗУРГАА. БУСАД .....	3

## КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

1.1. Энэхүү журмын зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Компанийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн бусад актын хүрээнд "Франкфурт Капитал ББСБ" ХХК-ийн хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд түгээх, сурталчлах, буруутай этгээдэд хариуцлага тооцох зэрэг харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 2.1. Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.
- 2.2. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх.
- 2.3. Мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх.
- 2.4. Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх.
- 2.5. Мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш байх.

### ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, НИЙТЭД ИЛ БОЛГОХ МЭДЭЭЛЛҮҮД

3.1. Компанийн зүгээс дараах мэдээллийг олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулах, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар зөв ойлголт төрүүлэх, хөрөнгө оруулагч татах зорилгоор нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайт, веб хуудас, олон нийтийн радио, телевиз зэргээр мэдээллийг нийтэд нийлүүлж ил болгож болно. Үүнд:

3.1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

3.1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;

3.1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;

3.1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;

3.1.5. Хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааны статистик мэдээлэл;

3.1.6. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;

3.1.7. Аудитын байгууллагаар баталгаажсан хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;

3.1.8. Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны мэдээлэл;



3.1.9. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, хүү, шимтгэлийн хэмжээ, төлбөр төлөх дансны дугаар;

3.1.10. Шаардлагатай тохиолдолд компанийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

3.1.11. Хууль тогтоомжид заасан бусад.

### **ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ, ЗӨВШӨӨРӨЛ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ.**

4.1. Иргэн, хуулийн этгээд Франкфурт Капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг, үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны дугаар, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны мэдээлэл зэргийг нээлттэй хэлбэрээр авах эх үүсвэрийг /хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайт, веб хуудас, олон нийтийн радио, телевиз/ хангаж ажиллах талаар Франкфурт Капитал ББСБ ХХК-аас тодорхой ажиллагаануудыг зохион байгуулж, өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг шинэчилж байх.

4.1.1. Хүн, хуулийн этгээд мэдээллийг хүсэлт гаргаж, эсхүл цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байршуулсан мэдээллийг хүсэлт гаргалгүйгээр тухайн цахим хуудсанд хандаж авч болно.

4.2. Хүнд хамаарах хаалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр хуульд заасан зорилго, нөхцөл, журмын дагуу ашиглана.

4.2.1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах бөгөөд харилцагчдын бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон бусад асуудлыг хөндсөн мэдээллийг чандлан нууцлах, харилцагчийн эрхийг хүндэтгэх, зээлийн үйл ажиллагаатай холбоотой нууцлалын зэрэгт орох бичиг баримтын хадгалалт, хамгаалалтыг ББСБ хариуцна.

4.2.2. Зээлийн хорооны дарга, гишүүд, ахлах эдийн засагч, зээлийн эдийн засагч нар зээлдэгчийн талаар аливаа мэдээллийг эрх бүхий этгээдээс бусад этгээдэд санаатай буюу санамсаргүйгээр дамжуулах, мэдээлэхийг хориглоно.

Эрх бүхий этгээдэд дараах байгууллагууд орно.

-Хөндлөнгийн аудит болон Санхүүгийн зохицуулах хороо ажлын шаардлагаар удирдах албан тушаалтан албан ёсоор хандах;

-Бүх шатны Прокурорын байгууллагаас захирамж, удирдлагын албан тоотоор хандах;

-Бүх шатны Шүүхийн байгууллага захирамж, удирдлагын албан тоотоор хандах;

-Бүх шатны Цагдаагийн байгууллагын удирдлагын албан тоотоор хандах;

-Тагнуулын Ерөнхий газрын удирдлагын албан тоотоор хандах;

-Харилцагч өөрөө бичгээр хүсэлтээ гаргах.

Зээлийн ажилтан нь дээр заасан эрх бүхий этгээдэд харилцагчийн талаарх аливаа мэдээллийг дамжуулахдаа тухайн ББСБ-ын хуульчид мэдэгдэж Гүйцэтгэх захирал, Дэд захирлын хяналт доор шилжүүлнэ.

Зээлийн ажилтан нь эрх бүхий этгээдэд мэдээлэл дамжуулсан тохиолдолд эрх бүхий этгээдээс мэдээлэл хүссэн тухай албан тоотыг баримтжуулан үлдээнэ.

**4.3. Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа дараах нөхцөлийг танилцуулна.**

4.3.1. Мэдээлэл авах зорилго;

4.3.2. Мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;

4.3.3. Мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;

4.3.4. Авах мэдээллийн жагсаалт, мэдээлэл авах хэлбэр;

4.3.5. Мэдээлэл боловсруулах, ашиглах хүрээ, хадгалах хугацаа;

4.3.6. Мэдээллийг ил болгох эсэх /Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд/;

4.3.7. Мэдээллийг бусдад дамжуулах эсэх /Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд/;

4.3.8. Хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг нийтэд тараахыг хориглоно.

#### **ТАВ. ТАЙЛАГНАЛ.**

5.1. Компани нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлсэний үндсэн дээр үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг ТУЗ-д жилийн эцсээр тайлагнаж байх.

5.2. Нийтэд хагас жил болон бүтэн жилийн санхүүгийн аудитлагдсан тайланг цахим сүлжээнд байршуулж байх.

5.3. Хөрөнгө оруулалт татах, санхүүжүүлэх зорилгоор гаргасан, үнэт цаасны тоо ширхэг, нэгжийн үнэ, татан төвлөрүүлсэн хөрөнгийн талаар нийтэд ил тодоор тайлагнаж байх.

#### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ.**

6.1. Энэхүү журмыг зөрчсөний улмаас гуравдагч этгээдэд хохирол учирсан бол зөрчлийн шинжээс нь хамааруулан Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр холбогдох байгууллагад мэдэгдэнэ.